



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 13

Хэрлэн сум

Татварын хэлтсийн Жижиг татвар төлөгчтэй
харилцах тасгийн Татварын улсын байцаагчийн
сул орон тоонд нэр дэвшүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.1.3 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам"-ын 1.6, 5.7, 3.5, 3.5.4, 2019 оны 14 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам"-ын 7.2, 7.3, 7.4, 7.6, 7.7-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төрийн албаны тусгай шалгалтаар хамгийн өндөр оноо /81/ авсан Оюунбилэгийн Сэдэдийг Татварын хэлтсийн Жижиг татвар төлөгчтэй харилцах тасгийн Татварын улсын байцаагчийн сул орон тоонд томилуулахаар нэр дэвшүүлсүгэй.

2. Нэр дэвшигч О.Сэдэдийг тухайн албан тушаалд томилсон шийдвэрийг ажлын 14 өдрийн дотор албан бичгээр ирүүлэх шаардлагатайг Татварын ерөнхий газрын дарга /Б.Заяабал/-д зөвлөсүгэй.

3. Энэхүү тогтоолыг Татварын хэлтсийн даргад хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ш.Эрдэнэжаргал/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ГАНБААТАР